

Гандантэгчэнлин хийдийн гүн ухаантан хоёр ламтны номын цагаан буяныг эргэн дурсахуй

Ш.Сонинбаяр* (МБШТГХ)

Монголын нэртэй эрдэмтэн мэргэд, гадаадын дорно дахины судлаач нэртэй эрдэмтийн дунд нэр алдар нь түгсэн их номч гүн ухаантан, гавж багш гэж алдаршсан хэргийн учир нэрийг нь өгүүлвээс Т.Данзан-Одсэр (1901-1978), Ш.Иштавхай (1902-1972) нар нь хуучин Халхын Сэцэн хан аймгийн Боржигон Сэцэн вангийн хошууны Баруун чойрын хийдэд бага наснаасаа шавилан сууж, 1940-өөд оны сүүлчээс Гандантэгчэнлин хийдэд шавилан сууж, 1970-аад он гартал хамтран ном эрдмийн ажлыг эрхэлсээр насан өөд болцгоосон юм. Бага насандаа энэ хоёр лам Баруун чойрын хийдэд Ловон хувилгаан Агваанданзаням, Лүнгийн багш гэж алдаршсан Шийравжалцан гавж, Баруун урд лам гэж алдаршсан Дамбийням равжамба зэрэг тухайн үеийн Боржигоны Баруун чойрын нэртэй эрдэмтдээр ном эрдэм заалгаж, Түвд хэл, гүн ухааны талаар өндөр боловсрол эзэмшиж 1930-аад оны сүүлчээр гүн ухааны гавж, гэвш болцгоож байжээ. Энэ хоёр лам баруун чойрын хийдэд сууж байхдаа өмнө дурдсан Ловон хувилгаан, Дамбийням равжамба нараар дуун ухаан, яруу найргийн онол, түвд хэлний зүйг заалгаж түвд хэлээр ном зохиож бичих дадлага олж авцгааж байжээ. 1930-аад оны эхээр тухайн хийдийн захиргаанаас гавж багшийг лам хүүхдүүдэд монгол бичиг заах багшаар томилогдож ажиллахдаа Дамбийням равжамбын зохиосон "Уншсанаар тус бүтэх" хэмээх түвд хэлээр монгол бичиг сурахад зориулагдсан цагаан толгойгоор зааж байсан байна. Энэ хоёр ламаар Баруун чойрын ловон багш ном судар бичүүлэх бичээч болгож байсан нь ном зохиол бичиж туурвихад нь нөлөөлсөн гэж үзүүштэй байна.

1937 онд сүм хийд хаасны дараа ном эрдмээ орхилгүй үргэлжлүүлсээр 1940-өөд оны эхээр Гандантэгчэнлин хийдэд хоёулаа шавилан сууцгааж, 1950-аад оны эхээр Гандантэгчэнлин хийдэд байгуулагдсан ном орчуулах комиссын бүрэлдэхүүнд багтаж Гандантэгчэнлин хийдийн хамба лам Н.Эрдэнэпилийн удирдаж байсан орчуулгын комиссыг толгойлж ажиллаж байх үедээ хурлын "Цогчин уншлага", "Магтаал" зэргийг монгол хэлэнд орчуулж, хурлын уншлаганд монголоор унших ажлын гол

*МБШТөв Гандантэгчэнлин хийдийн ЭСХ-ийн захирал, профессор, доктор

хэрэглэгдэхүүн болох монголоор орчуулсан номуудыг нь бэлтгэж байсан байна. 1959 онд Улаанбаатар хотноо хуралдах Олон Улсын Монголч эрдэмтдийн анхдугаар хуралд зориулж, Буриадын эрдэмтэн Номтын Ринчингийн "Түвд Монгол толь бичиг"-ийг гүйцээн гаргаж хэвлүүлэхийг академич Б.Ринчин, Гандантэгчэнлин хийдийн хамба лам Эрдэнэпил, гэсгүй Гомбодоо нарт хүлээлгэн өгч, 1959 онд болох хурлаас өмнө гаргахыг даалгаж үлдээсэн юм. Үүний дагуу Гандантэгчэнлин хийдийн эрдэмтэн лам нарыг дайчлан оролцуулж, академич Б.Ринчинийн удирдлагаар Гандан хийдийн их гэсгүй Гомбодоо, орчуулагч, гавж Ц.Дорж, гавж Гомбожав, гэвш Дугар, гавж Очир, гавж Данзан-Одсэр, гэвш Иштавхай, гавж Дамдинсүрэн, гэвш Аюуш, эмч Ядамсүрэн, зурхайч Доржжанцан, гэвш Чогжав, Батсүх, бичээч гавж Цэрэннамжил, Базаррагчаа, Дагвадорж, Баарай, Жамсранжав нар 16-р жарны тахиа жилд эхлэн, мөн жарны 48-р он гахай жилд гүйцээн төгсгөсөн байна. 1959 онд хэвлэн гаргасан энэхүү "Түвд монгол толь бичгийн зүүлт тайлбарууд", "Хатуу нэр томъёоны үгс"-ийн хэсгийг гавж багш Т.Данзан-Одсэр, Ш.Иштавхай нар голлон орчуулж гаргасан байдаг юм. Өмнө өгүүлсэн Гандантэгчэнлин хийдийн орчуулагч бичээч лам нар, ШУХ-ийн эрдэмтэдтэй хамтран нийтлүүлсэн энэхүү түвд монгол толь бичиг нь XVIII, XIX зууны үед хэвлэгдсэн "түвд монгол толь бичиг"-үүдээс ихээхэн ялгаатай бөгөөд үгийн тайлбаруудыг дэлгэрэнгүй хийснээрээ онцлог болжээ. Сумади Раднаагийн энэ толь бичгийг XX зууны үед гаргасан шилдэг толь бичгийн тоонд оруулж үздэг юм.

1960 онд Гандантэгчэнлин хийдийн хамба ламаар өргөмжлөгдсөн Их хүрээний гавж Самаагийн Гомбожав орчуулгын комиссын бүрэлдэхүүнийг өргөтгөж, сайн орчуулагч эрдэмтэй лам нараас нэмж оруулж байжээ. Энэ үед Гандантэгчэнлин хийдийн эрдэм судалгааны тасаг болох "Номын гэр"-ийг байгуулж эрхлэгчээр нь гавж багш Т.Данзан-Одсэр, голлох орчуулагчаар гэвш Ш.Иштавхай нар ажиллах болсон юм. Энэ үеэс ШУА-ын эрдэмтэд, МУИС-ийн эрдэмтэн багш нартай өргөн харилцаатай болж, Гандантэгчэнлин хийдийн номын гэрийн хоёр их ламтныг Монголын нэртэй эрдэмтэд андахгүй мэддэг болсон юм. Тухайлбал: Энэ хоёр ламтаны гэрээр академич Б.Ринчин, академич Ц.Дамдинсүрэн, академич Ш.Лувсанвандан, академич Х.Пэрлээ, академич Ч.Жүгдэр, доктор Чой. Лувсанжав багш, одон орон судлаач С.Нинжбадгар, академич Ш.Бира, залуу эрдэмтдээс Л.Хүрэлбаатар, Д.Ёндон, С.Дулам нарын зэрэг эрдэмтэн мэргэд бараалхан ном эрдэм заалган хөтлүүлж байсан нь тодорхой юм. Ялангуяа номын гэрийн орчуулагч Иштавхай ламтнаар академич Ц.Дамдинсүрэн, академич Ш.Бира, доктор Х.Гаадан, ШДС-н оюутан С.Ламчин нар эртний энэтхэгийн "Зохист аялгууны толь" хэмээх номыг хөтлүүлж байсан юм.

Номын гэрийн эрдэмтэн мэргэдийн нийтлүүлж гаргасан гол бүтээл болох Шашны гүн ухааны цоморлиг "Дармапада" номыг 1966 онд хамба лам С.Гомбожав эрхлэн гавж Т.Данзан-Одсэр, гэвш Ламаажав, гэвш Ш.Иштавхай, гэвш С.Дашдамба нар орчуулан нийтлүүлсэн юм. 1960-аад оны дундуур номч мэргэн гавж С.Гомбожав Өвөр Монголын Бааран хошууны гэвш Дармадалагийн "Хор чойнжүн" хэмээх Монголын шашны түүхийн зохиолыг түвд хэлнээс орчуулж номын гэрийн лам нараар хянуулж, хэвлэлд бэлтгэж байсан байна. Номын гэрийн лам нар нийлж хүрээ барын Ганжуурын шүйдэг хийж бэлтгэж байсан боловч энэ зохиол нь олдоогүй юм. Мөн

түүнээс гадна Номын гэрийн лам нар нийлж Монголын шашны түүхийн тухай номыг бэлтгэж байсан боловч хэвлүүлж амжаагүй байсныг Номын гэрт бичээч байсан Цорж лам Г.Диваасамбуу гуай 2005 онд хэвлүүлсэн юм.

1960-аад оны сүүлчээр Оросын монголч эрдэмтэн Ю.Рерих академич Ц.Дамдинсүрэн, академич Б.Ринчин, академич Ч.Жүгдэр, Гандантэгчэнлин хийдийн хамба лам, гавж С.Гомбожав, гавж Т.Данзан-Одсэр нартай уулзаж, ШДС-ийг Улаанбаатар хотод байгуулах талаар Ю.Цэдэнбал даргатай уулзан ярилцаж байсан байна. Энэ ярианы үр дүнд 1970 онд Гандантэгчэнлин хийдийг түшиглэж, ШДСургууль байгуулагдсан юм. Гандантэгчэнлин хийдийн Номын гэрийн эрдэмтэн лам нар ШДС-ийн багш болцгоосон. Энэ үед 1970 онд ШДС-ийн оюутнуудад анхлан түвд хэл сурахад нь зориулж "Түвд цагаан толгойг" гавж Т.Данзан-Одсэр зохиож гаргасан юм. Тэрхүү цагаан толгойн онцлог нь хуучин цагаан толгой заадаг уламжлалаас өөр, жишээ нь: хагархай "га" үсгийг анхны "га", битүү "га" үсгийг хамигаагийн "га", бяцхан "а"-г миний "а" гэх мэтээр түвдийн гучин үсэг тус бүрийг монгол үгэнд ордог орчуулгаар нь зааж сургаж байсан нь хуучин түвд хэл сургадаг уламжлалыг нэлээд өөрчилсөн шинэлэг сургалт болж байсан юм. Энэ сургалт нь түвд үсэг нүдлэхээс эхлээд орчуулж сурахад ихээхэн ач холбогдолтой сургалтын өвөрмөц арга юм. 1970 онд ШДС-ийн анхны оюутнууд болох Хамба лам, гавж Д.Чойжамц, Дашчойлин хийдийн хамба лам, Доктор Ц.Дамбажав нарын зэрэг эхний гурван курсын оюутнууд энэ цагаан толгойгоор түвд хэл сурцгаасан юм. Гавж багш бидэнд ном айлдахдаа: "Цигийн намба машар вар Донжий намба галаа жи" хэмээн айлдаж заримдаа Гүнтэн гэгээний айлдсан: "Донжий гамбуу цигий харваа ла дэн" хэмээх сургаалиас олонтаа татдаг байсан билээ. Эдгээр түвд үгс нь: "Үгийн байдал нь эс ургаваас утга нь хаанаас төрөх вэ", "Утгын өвгөн үгийн таяганд тулж босдог" хэмээсэн утгатай үг юм. Дээр өгүүлсэн түвд сургаал айлдварууд нь ном эрдэмд суралцахад тухайн хэлний үг үсгийг сайтар нүдлэхээс утгыг нь зөв гаргаж орчуулах нь чухал болохыг эрдэмтэн багш нар олонтаа айлдаж байсны нэгэн жишээ юм.